

## ГЛОБАЛЧЛАЛ ХИЙГЭЭД ГЛОБАЛ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ҮНДЭСНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТОЛЦОО

*Ц.Баатар\**

### **Харилцан хамаарал хийгээд бүсчлэн хөгжих үзэл санаа**

Глобал үйл явц түгээмэл шинжтэй хийгээд глобалчлалын зарчмууд бүх бүлэг орон, дэлхийн аж ахуйн бүх хүрээнд хэрэглэгдэж болох, эдгээр хүрээнд таатай нөлөөлж байгаа тухай төсөөлөл нь эдийн засгийн глобалчлалын мөн чанарыг ойлгон мэдэх эхний үе шатанд зонхилж байсан юм. Гэвч зах хязгаар орнуудын эдийн засагт эмх замбараагүй байдал гарч, хөгжингүй улсуудын валют, фондын зах зээл үйл ажиллагаа тасалдаж байсан нь глобал үйл явц ашиг тустай түгээмэл шинжтэй, энд улс орнууд эдийн засаг, үйлдвэрлэлийн үзүүлэлт, хөдөлмөрийн бүтээмжийн түвшингээр ойртон нягтрах хандлага гарцаагүй зонхилж байна гэдгийг шүүмжлэгчдийн байр суурийг эрс идэвхижүүлсэн юм. Глобалчлал орлогын өсөлтөд тэр бүрий түлхэц өгдөггүй, капиталын зах зээлийн нээлттэй байдал, чөлөөт худалдаа, хувьчлал нь хөгжиж буй орнуудыг бүр илүү тогтворгүй болгож байна гэсэн болгоомжлол үндэслэлгүй биш байв.<sup>1</sup>

Нөхцөл байдлын сонин үзэгдэл дараахи зүйлд оршино: юуны өмнө бүлэг хөгжингүй улсууд олон улсын хөдөлмөрийн хуваарийн гүнзгийрэлтийн давуу талыг олж авч байгааг хүлээн зөвшөөрөхдөө, хөгжиж буй (болон шилжилтийн эдийн засагтай) орнууд глобал үйл явцад оролцохоос аргагүйд хүрсэн төдийгүй, ингэж оролцохыг туйлаас сонирхож байгаа юм. Дэлхийн аж ахуйгаас зожигрон тусгаарлах сонголт нь эцсийн бүлэгт өсөлтийн хурдацыг бууруулж, технологи, санхүүгийн болон мэдээллийн нөөц, хүн капиталын хомсдол, хөгжлийн гадаад шижим түлхэцгүй байдлаас болоод ужиг зогсонги байдалд хүргэх аюултай юм.

Энэ нь улам олон үндэсний эдийн засаг глобал эдийн засгийн орон зайд интеграцчлагдаж байна хэмээн мэдэгдэх боломжийг глобалчлалын талынханд олгож байна. Яг үнэндээ бол одоогоор бид улс орнуудын аж ахуйн тогтолцооны интеграцитай биш, харин ердөө л гадаад худалдаа болон олон улсын капиталын зах зээлийн өсөлттэй л харьцаж байгаа билээ. Улс орны аж ахуйн тогтолцооны интеграцитай харьцах нь илүү нарийн түвэгтэй юм. Учир нь шинэ бүрэн эрхт улсууд үүссэнээр ийм тогтолцооны тоо бараг хоёр дахин олширч, одоо 200

\* Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

орчим болоод байна. Улс орнуудын тогтолцоо жижигэрч байгааг санхүү, үйлдвэрлэл, технологийн болон оюуны хүчин чадлын глобал төвүүд эдийн засгийн шинэ орон зайг эзэмших явдлыг хөнгөвчилж өгч буй хүчин зүйл болгон ашиглаж байгаа мэт сэтгэгдэл төрж байна.

Тийнхүү бас нэг сонин үзэгдлийг дурдая: худалдаа, санхүүгийн солилцоо өсч, хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай орнуудад Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаа өргөжиж буй нөхцөлд энэ бүлэг орнуудын харилцан хамаарал гэхээсээ төвөөс шууд хамаарах явдал болон үүний зэрэгцээгээр төв нь дэлхийн бусад хэсгээс аж ахуйн талаар өрөөсгөл тусгаарлагдмал байдалд орох явдал хүчтэй болж байна. Хоёр бүлэг орнуудын харилцан ажиллагааны тэгш биш байдал нь эдийн засгийн үйл ажиллагааг үнэлэхэд уламжлал ёсоор хэрэглэдэг тооны үзүүлэлтийн ялгаанд төдийгүй, мөн орчин үеийн болон маш орчин үеийн мэдээлэл, үйлдвэрлэлийн технологи, тухайлбал өрсөлдөгчдийн хувьд хүрэх боломжгүй (юмуу хүрэхэд бэрх) хүрээнд эрэлт бий болгох технологийг мэдэж авч, эзэмших явдлыг тодорхойлж буй үзүүлэлтээр бас улам их хэмжээтэй илэрч байгаа юм.<sup>2</sup> Төвийн тусгаарлагдмал байдал хэвээр байгаа төдийгүй, аж үйлдвэржилтийн дараахи эдийн засгийн шийдвэрлэх хэсгүүдэд түүний монополит байр суурь нь бэхжихийн хэрээр гүнзгийрч байна.

Оросын зарим эрдэмтэн, жишээ нь В.Иноземцев энэ нөхцөл байдлыг Өрнөд өөрийгөө эдийн засаг, нийгмийн талаар тусгаарлаж байгаа хэрэг гэж бүр илүү хатуухан тодорхойлдог. “Хэрвээ 50-иад оны эхээр АНУ болон Өрнөд Европын орнууд өөрсдийн гадаадын хөрөнгө оруулалтын 50 орчим хувийг л бие биедээ оруулж байсан бол, өнөөдөр энэ үзүүлэлт 70%-иас давж байна. Цаашилбал, америк, европын компаниудын гаргаж байгаа үнэт цаасны 90% нь АНУ болон Европын холбооны хөрөнгө оруулагчдынх бөгөөд харин дэлхийн худалдааны эргэлтийн 70%-ийг Европын орнууд, АНУ, Канадын хоорондын хэлэлцээр эзэлж байна”.<sup>3</sup>

Судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, мэдээллийн технологи, оюуны бусад өмчийн ихээхэн хэсэг төвд төвлөрч байгааг үүн дээр нэмж хэлж болно. Хамгийн их глобалчлагдсан санхүүгийн секторт ч тусгаарлагдмал байдалд орох хандлага илэрч байгаа юм. “Өнгөрсөн зууны эхэнд Лондоны санхүүгийн биржид арилжаалагдаж байсан үнэт цаасны 60%-ийг гадаадын эмитентүүд гаргасан байна. Одоо Нью-Йоркийн фондын биржүүдэд эргэлтийн 90% нь гадаадын эмитентүүдэд ногдож байна. Өнөөдөр гадаад худалдааны эргэлтийн 6%-иас илүүгүй нь Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын хүрээнээс хальж байна”.<sup>4</sup>

Дэлхийн аж ахуйд эдийн засаг, нийгэм, технологийн болон институцийн туйлын өөр өөр тодорхойлолт бүхий хоёр том бүлэг орон тодорхой харагдсаар байгаа юм. Энэ нөхцөл байдал нь л гэхэд глобал эдийн засгийн үйл явц гарцаагүй түгээмэл шинжтэй гэдэгт эргэлзэхэд хүргэж байна. Эдгээр үйл явцын нийтлэг вектор нь ойртон нягтрах чиг хандлагатай байна гэдгийг зөвшөөрч болно, гэхдээ ингэж ойртон нягтрах замд болон, түүний дотор бүрнээ орших чадвартай үндэстний өвөрмөц бүтэцүүд хэсэг хэсэг болж, эвдэрч нурах шат гарцаагүй юм.

Хэсэгчилэл нь улс орнуудын дотоодод зүүрмэглэж байсан, үргэлжийн эвдэн нураагч үйл явцыг сэргээж байна. (тухайлбал эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд омог аймгийн бүлгүүд нягтарч, салан тусгаарлах санаа бодолтой бүс нутгийн хамтын нийгэмлэгүүд бий болж, янз бүрийн шашины хооронд маргаан дэгдэж байгаа юм) Глобалчлал нь төрийн үүргийг нарийсган, сулруулж байгаа ээдрээтэй нөхцөл байдал бий болж, үүний хамт үндэсний болон бүс нутгийн түвшинд түүний бий болгож буй хэсэгчилэл нь зөрчил, маргааныг хурцатгаж, үүнийг гэтлэн давахын тулд хүчтэй төрийн оролцоо шаардагдаж байна. Зах хязгаарын орнууд технологийн эндогенийн (дотоодын) дэвшил бүхий эдийн засгийн өсөлтийн шинэ шинэ загварыг эрж хайж буй нь хэсэгчиллийн нэг үр дагавар болж байна.<sup>5</sup>

Сүрхий хүч чармайлт тавьж байгаа хэдий ч, зах хязгаарын орнууд сүүлийн хэдэн арван жилийн туршид энэ байдлын гүнзгийрэлтийг мэдэгдэхүйц өөрчилж чадаагүй юм. Нэг хүнд ногдуулан тооцвол энэ нь 8 дахин үзүүлэлтийн эргэн тойронд хэлбэлзэж байна. Эрчимтэй хөгжиж буй Хятад улс Японоос барагцаалбал 6.8 дахин, Европын холбооноос 6.5, АНУ-аас 8,9 дахин, Энэтхэг 13.11 болон 16 дахин хоцорч байгаа юм. Хоёр мянганы заагт шилжилтийн эдийн засагтай бүлэг орнууд энэ үзүүлэлтээр хөгжингүй орнуудаас 4.4 дахин, түүний дотор Орос 3.8 дахин хоцорчээ.<sup>6</sup> (World Economic Outlook. Wash., 2000. P. 69-өөр тооцоолжээ. Transition Newsletter. October, November, December 2001. V.12. №4. P.1-ийн тоо баримт бүр тааруу байна. Энэ тооцоогоор, хөгжингүй ертөнцийн 900 сая оршин суугч болон хөгжиж буй ертөнцийн 5.1 тэрбум оршин суугчийн орлогын түвшингийн 13 гаруй дахин ялгаа хэвээр байна (26 болон 1,9 мянган доллар. Ингэхдээ хэрвээ зах хязгаар нутгийн 3 тэрбум оршин суугч нэг хүнд ногдох орлогын хэмжээний ялгааг төвөөс багасгаж чадаж байгаа ч, 2 тэрбум гаруй хүний хувьд энэ ялгаа нэмэгдсээр байна. Тиймээс, хэсэгчилэл нь Умард, Өмнөдийн шугамаар төдийгүй, Өмнөдийн дотоодод бас дэлгэрч байгаа бөгөөд Өмнөдөд энэ үзүүлэлтийн векторын чиглэлээр хоёр бүлэг бүрэлдэж байна. Энэ нь

глобал үйл явц түгээмэл шинжтэй гэдэгт эргэлзэх боломжийг бас дахин олгож байна)

Дэлхийн худалдаа болон улс хоорондын капиталын шилжилтэд оролцох оролцооны ялгаа бүр ч их юм. Хэрвээ 1990 онд дэлхийн үнэт цаасны зах зээлийн капиталчлалын 30% нь АНУ-д ногдож байсан бол, одоо 50%-д хүрч, өрнөд европын зах зээлүүдийн хувь хэмжээ 31, Японых 11% байна. 1990 онд төвийн үнэт цаасны зах зээлүүдийн капиталчлал дэлхийн нийт зах зээлийн нийт капиталчлалын 86% байсан бол, одоо 92% болж өсчээ.<sup>7</sup> Тийнхүү төв нь зах хязгаараасаа тусгаарлагдсан байдалд орох явдал ихсэж, эдийн засгийн нэн чухал чухал үзүүлэлтийн нэгнийх нь талаар ялгаа нэмэгдэж буй хоёр үйл явц энд харагдаж байна. Худалдаа ч мөн ийм байдалтай байгаа юм.

Глобалчлал нь олон улсын эдийн засгийн харилцаанд оролцогч орнууд болон интеграцийн нэгдлүүдийг өрсөлдөөнт тэмцэлд татан оруулж байгаа төдийгүй, үндэсний, салбар бүс нутгийн болон бүс нутгийн эдийн засгийг орон нутгийн өрсөлдөгчдийн байр суурийг бэхжүүлэхийг огтхон ч сонирхдоггүй глобал түвшингийн тоглогчдын өрсөлдөөний талбар болгож байна. Дэлхийн худалдааны байгууллагад (ДХБ) нэгдэн орох гэж байгаатай холбогдон Орост өрнөж буй хурц маргаан шүүмжлэл нь энэ асуудлын тулгамдсан шинж, цар хүрээний тухай төсөөлөл өгч байгаа юм.

ДНБ болон хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн хурдацыг бууруулах хандлагыг бүрдүүлж өгөх учиртай гэх глобал үйл явц түгээмэл шинж чанартай мэтээр нотолж байгаа ч, бүхэнд нээлттэй байгаа орчин үеийн технологи болон бусад нөөцийн дүнд ийм үйл явц нь дэлхийн аж ахуйн аж үйлдвэрийн секторт л (төвд) байгаа юм.

Энэ нөхцөл байдал нь эндогенийн өсөлтийн загварын нэр хүнд өсч байгааг ч тайлбарлаж буй нь тодорхой. Ромерогийн гурван секторт загварт (НИОКР – завсрын бүтээгдэхүүн – эцсийн бүтээгдэхүүн) эх орны шинжлэх ухаан, боловсролын хөгжил гол байр суурьтай юм. Глобалчлал эдийн засгийн эндогенийн өсөлтийн үзэл баримтлалыг өөрчлөн, түүнд гадаад орчныг зүй ёсоор оруулж өгч байна. Глобалчлалын өмнөх үед эндогенийн загваруудад (хамгийн бага хэрэгцээг хангах, хамт олноороо өөрийгөө хангах г.м.) өөрийн хүчинд тулгуурлахыг ихэд онцолж байв. Харин одоо үндэсний эдийн засгийн хүрээний гадна идэвхитэй үйл ажиллагаа явуулах шаардлагатайг тэмдэглэж, гэхдээ эдгээр экзогенийн хүчин зүйлүүд нь дотоодын цохилтыг эсэргүүцэх төдийгүй, эх орны үйлдвэрийн өрсөлдөх чадвартай, юуны өмнө шилдэг технологийн бүтээгдэхүүнийг борлуулах орон зайг эрж олох боломж олгож буй аж ахуйн дотоодын оршин тогтнох чадвар бүхий бүтэцтэй хосолсноор л үр ашигтай байж чадна.

Байгалийн дундаж нөөцтэй барагцаалбал 300 сая хэрэглэгчийн зах зээлийн багтаамж бүхий эдийн засгийн орон зай глобал шалгуураар оршин тогтнох чадвартай бүтэцүүд байгуулах ажлыг хангаж чадна гэсэн сэтгэгдэл төрж байна. Одоо энэ нь АНУ, Хятад, Энэтхэг, НАФТА, Европын холбоо, МЕРКОСУР, АСЕАН (харин тарж бутрахаас өмнө Зөвлөлт Холбоот Улс) юм. Өсөлтийн эндогенийн эх сурвалжид тулгуурлах нь гадаад ертөнцөд их нээлттэй нөхцөлд ч ийм томхон бүтэцүүдийг хангалттай тогтвортой болгож байгаа билээ.

Энэ байдлыг онцгой анхаарах хэрэгтэй. Гаалийн өндөр татвар, квот, захиргааны хязгаарлалт зэргийн тусламжтайгаар, өөрөөр хэлбэл эх орны үйлдвэрлэгчдэд хүлэмжийн нөхцөл бүрдүүлэх замаар гадаад ертөнцөөс өөрийгөө хамгаалах шаардлага хэмээн ойлгож буй эндогенийн хөгжил бүтэлгүйтэх тавилантай юм. Гэвч харилцан ажиллагаа гаднын шижим түлхэцээр л өргөждөг гэсэн тийм туйлшралаас ч зайлсхийх хэрэгтэй. Харилцан ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр нийгмийн хүрээ, шинжлэх ухаан, боловсрол, эх орны НИОКР-ыг хөгжүүлэх, менежмент, маркетингийг боловсронгуй болгох зэрэг тийм дотоод хүчин зүйл улам их үүрэг гүйцэтгэх ёстойг онцлон тэмдэглэмээр байна.

Эдгээр дурдсан шалгуурт сэтгэл дундуур байгаа зах хязгаарын алслагдсан бүтцүүд (зарим орон) салбар бүс нутгийн болон бүс нутгийн интеграцийг ашиглан, аж үйлдвэрийн орнуудын тус тусдаа тоглогчид болон интеграцийн бүлгүүдтэй хийж буй хэлэлцээн дээр байр сууриа бэхжүүлж, дэлхийн зах зээлд өөрсдийн байр суурийг бататган, гадаад таагүй орчныг эсэргүүцэх чадвараа дээшлүүлж чадна.

Оросын хувьд гэвэл, худалдааны чөлөөт бүс, интеграцийн бүлэглэлийн (Евроазийн эдийн засгийн холбоог өргөжүүлэх юмуу ямар нэг өөр бүтэц байгуулах замаар болох юм) хэлбэрээр эдийн засгийн орон зайг хөрш зэргэлдээ холбогдох орнуудтай хамтран байгуулах туйлын шаардлагатай тухай дүгнэлт гарч ирж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхгүйгээр урт хугацааны ирээдүйд тогтвортой өсөлтийг хангахаар тооцоолоход хэцүү юм. Ийм үзүүлэлт бүхий эдийн засгийн орон зайн хүрээнд л Орос улс үйлдвэрлэл, технологи, шинэлэг судалгааны салбарт өөрийн чадавхийг бүрэн хэрэгжүүлэх боломж олж авч, төвийн улс орнууд болон бүлэглэлүүдтэй эдийн засгийн талаар илүү үр ашигтай харилцан ажиллах боломжтой болно.

Зөвлөлтийн дараахи эдийн засгийн нэгдмэл орон зай байгуулах зүй ёсны шаардлагыг ТУХН-ийн бусад орон ч улам бүр ойлгож эхэлж байна. Энэ чиг хандлага нь ялангуяа эдгээр орон ДХБ-д нэгдэн орох гэж байгаатай холбогдон тодорхой харагдах болсон билээ. Эхний гурван орон (1998 онд Киргиз, 2000 онд Гүрж, 2001 онд Молдав)

ДХБ-д элсэхдээ зөвшин тохироогүй үйл ажиллагаа тус тусдаа явуулсан нь шинэ гишүүдэд хүсэн хүлээсэн үр дүн өгөөгүй бөгөөд харин ч бүс нутгийн интеграцийн үйл явцыг ноцтой чөдөрлөж, Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд гаалийн холбоо байгуулах боломжгүй болгосон. Хэрвээ хэлэлцээ хийж буй бас зургаан орон ДХБ-д зөвшин тохиролцолгүйгээр нэгдвэл, ТУХН-ийн бүс нутагт худалдаа, эдийн засгийн харилцаа шинэ бөгөөд бүр их бэрхшээлтэй тулгарна. Байдлыг засч залруулахыг эрмэлзэхдээ, зөвлөлтийн дараахи эдийн засгийн орон зай дахь харилцан ажиллах вектор задрахаас нэгдэх тийшээгээ өөрчлөгдөж эхэлж байх шиг байна.

Орос, Белорусь, Казахстан, Украины ерөнхийлөгч нар эдийн засгийн нэгдмэл орон зай байгуулах бодолтой байгаагаа саяхан мэдэгдсэн нь нэгдүгээрт, интеграцийн үйл явцыг мухардлаас гаргаж, хоёрдугаарт, ТУХН дэх эдийн засгийн чадавхиараа хоёрт ордог орныг энэ үйл явцад татан оролцуулах боломж олгож байна. Киргизийн удирдлага Евроазийн эдийн засгийн холбоонд оролцохтой холбогдуулан өөрийн нэгдсэн зарим болзлыг өөрчлөх саналыг ДХБ-д тавих бодолтой байгаагаа мэдэгдсэнийг бас тэмдэглэх хэрэгтэй. “Дөрвийн холбоонд”, тухайлбал өөрийн гадаад худалдааны томоохон түнш болох Орост хохирол учруулахгүй байхын тулд Украины төлөөлөгчдийн хэлэлцээ хийх байр суурийг өөрчлөх шаардлагатай байгаа тухай Украины ерөнхийлөгч Л.Кучма мэдэгдэж байв.

Хачирхалтай ч гэлээ, интеграцичлалын нөлөөгөөр хөгжингүй болон хөгжиж буй орнуудын интеграцийн нэгдлийн зорилтууд таарахгүй болсон. Эхний тохиолдолд эдийн засгийн үйл ажиллагааныхаа хүрээнд шинэ шинэ улсыг татан оролцуулж, өөрийн ирээдүйтэй шинэ шинэ технологийг улам өргөн дэлгэрүүлэх зорилгоор гадаад хүрээг анхаарах нь идэвхижиж байна. Хоёр дахь тохиолдолд, сул дорой болон дунд зэргийн хөгжилтэй орнуудын хувьд уламжлалт өсөлтийн тогтвортой хурдацыг хангах зорилтын зэрэгцээгээр, глобалчлалын зарим эвдэн бусниулагч үр дагаварыг сөрөн эсэргүүцэх зорилт тавигдаж байна. Энэ үр дагаварын цар хэмжээ нь глобалчлалын өдөөлтөд зах хязгаар олон орны дасан зохицох эдийн засаг, улс төрийн болон нийгмийн боломжоос давж байгаа юм.

Үүнтэй холбогдуулан В.Сергеевийн (Москвагийн олон улсын харилцааны их сургуулийн (У) стратегийн судалгааны төвийн захирал) бүтээлээс иш татах нь зүйтэй: “Тийнхүү глобалчлал нь “олон туйлт байдал”, гэхдээ улс төрийн биш, харин бүс нутаг-эдийн засгийн онцгой төрлийн “олон туйлт байдлыг” арилгахгүй, харин өвөрмөц байдлаар хүчтэй болгож байна”.

Асуудлын нэн ээдрээтэй байдал нь эдийн засгийн глобалчлалын үйл явцыг өөрийг нь хэсэгчилэхэд хүргэж байна. Олон улсын капиталын болон барааны зах зээлийн хувьд эрчимжилт хамгийн их байгаа бөгөөд өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээлүүдийн интеграцичлал өрнөж, уг интеграцичлалыг үндэсний аж ахуйн тогтолцооны интеграцичлалтай адилтган үзэх нь олонтоо байдаг. Үүний хамт эдийн засгийн бодлого, институцийн тогтолцоо, ажиллах хүчний зах зээл хоцорч байдгийн адил үндэсний аж ахуйн тогтолцоо хоцорч байгаа юм.

Глобал хэсгүүдийн хөгжил жигд бус байгаа нь нэгдмэл үйл явц болохын хувиар эдийн засгийн глобалчлалын нааштай, тогтвортой чанар гэгчид болгоомжлох санаа төрүүлж байна. “Business Week” сэтгүүл салбарын хандлагын хүрээнд дэлхийн асуудлыг шийдвэрлэх олон улсын тэргүүлэх институцуудын хандлагад анхаарал хандуулсан юм. Ж.Стиглиц Олон улсын валютын сангийн шүүмжлэлийг иш татахдаа, хэрэг дээрээ энэ байгууллага эдийн засгийн глобал ашиг сонирхолыг хэрэгжүүлэхээс капиталын глобал зах зээлийн ашиг сонирхолыг хэрэгжүүлэхэд шилжсэн юм гэж сэтгүүлд бичжээ.

### **Глобалчлалын эриний эдийн засгийн үр ашгийн шалгуур**

Нэгдэх эсвэл хэсэг хэсэг болох чиглэлийн хоёр өөр хандлага эдийн засгийн глобалчлалд байгааг хүлээн зөвшөөрөх нь аж ахуйн үйл ажиллагааны янз бүрийн түвшингийн үр ашиг болон тэдгээрийн нийцэл зохицлын шалгуурын тухай асуудлыг авч үзэхийг зүй ёсны шинжтэй болгож байна. Энэ өгүүлэлд олон улсын хөдөлмөрийн хуваарьт улс орны оролцооны үр ашигт үнэлгээ өгөх асуудлыг авч үзэж байгаа юм.

Улс орны дагналт нь нэг талаас, түүний талаархи гадаад эдийн засгийн орон зайн хэрэгцээгээр, нөгөө талаас, дэлхийн шалгуураар өрсөлдөх чадвартай бараа, үйлчилгээ үйлдвэрлэх түүний чадвараар тодорхойлогддог. Ингэхдээ олонхи тохиолдолд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, нийлүүлэгч нь аж ахуйн бүтэцүүд болж байдаг. Глобалчлалын үед бүтээгдэхүүний улам их хэсэг борлуулалтын багтаамжтай шинэ шинэ зах зээлийг эрж хайн үндэсний хилийг давж байна. Хэрвээ дэлхийн аж ахуйн глобалчлалын тухай сэдвийг авч үзвэл, нэгдмэл бүтцийн хувиар дэлхийн аж ахуйн байр сууринаас үр ашгийн шалгуур, өөрөөр хэлбэл үйлдвэрлэгчийн (экспортлогчийн) хувьд дэлхийн зах зээлд бий болсон үнээр борлуулах явдлыг ашигтай болгож буй үйлдвэрлэлийн зардлын тэр түвшинг тодорхойлогч түвшин хэмээн үзэх нь бүрнээ зүй ёсны юм. (хэрвээ ямар нэг үйлдвэрлэгчийн монополь байдлын тухай юмуу гадаад эдийн засгийн нөлөөллийн

тухай яриагүй бол) Бараа, үйлчилгээ бие даан үйлдвэрлэгчид энэ олон улсын шалгуурыг баримжаа болгодог бөгөөд хэрвээ уг шалгуур нь тэдний санаанд нийцэж буй ашигт ажиллагааг хангаж байгаа бол, олон улсын зах зээлд гардаг. Импортлогчид энэ төрлийн ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан, нийлүүлэгчийг сонгохдоо мөн ийм санаа бодлыг удирдлага болгодог юм.

Глобал үр ашгийн шалгуур нь үндэсний үйлдвэрлэгч, экспортлогч болон импортлогчдын үндэс болгож буй учир шалтгааны шинж чанарыг тодорхойлдог. Орост иймэрхүү байдал бий болсон бөгөөд түлш, түүхий эд, хар ба өнгөт металл, бусад зарим бараа үйлдвэрлэгч болон экспортлогчид дэлхийн зах зээлийн ашигтай байдлыг ашиглан, уламжлалт зах зээлүүдэд байр сууриа бэхжүүлж, шинэ шинэ зах зээлийг эзэмшиж байна. (Жишээ нь Оросын нефтийн болон хийн компаниуд гадаадад нефть боловсруулах завод, бензин түгээгүүрийн газар, хадгалах савууд олж авахыг эрмэлзэж, нефть болон хий дамжуулах хоолойн экспортын шинэ шинэ чиглэлийн төсөл боловсруулж; металлургичид шинэ зах зээлд батжиж авахын тулд хуучин зөвлөлтийн бүгд найрамдах улсууд болон гадаад орнуудын аль алинд үйлдвэртэй болж байна)

Дээр өгүүлсэн нөхцөл байдал нь аль ч орны хувьд нийтлэг шинжтэй бөгөөд экспортод түлхэц өгөхөөс татгалзахыг уриалж байгаа хэрэг ерөөс биш юм. Гэвч глобалчлалын өдөөлтөд нийцсэн эдийн засгийн бүтэцүүд бүрэлдэж бий болоогүй хөгжиж буй болон өөрчлөгдөж байгаа (шилжилтийн эдийн засагтай) орнуудад иймэрхүү сонголтын асуудал онцгой тулгамдсан шинжтэй юм. Ийм бүтэцүүд байхгүй нөхцөлд хэтэрхий нээлттэй байдал нь эдийн засгийн хөгжлийг урьдчилан таах аргагүй болгож, эдийн засгийн оновчтой бодлого боловсруулах, гадаад худалдааны бүтэцийг зохистой болгох боломж олгохгүй байна.

Оросын тухайд гэвэл, глобал, улс ардын аж ахуйн болон пүүсийн (экспортлогч, импортлогчийн) зэрэг янз бүрийн түвшингийн шалгуур таарч тохирохгүй байгаа нь төрийн бүтцийн болон аж үйлдвэрийн бодлого байхгүйгээс онцгой хүчтэй мэдрэгдэж байгаа. Аж ахуйн үйл ажиллагаанд оролцогч бүхний хувьд зохистой үр дүнд хүрэхийн тулд үр ашгийн энэ гурван түвшингийн шалгуурыг тааруулах зорилтыг шийдвэрлэх нь чухамхүү ийм бодлогоос шалтгаалж байна.

Түвшин тус бүрийн шалгуурын жин даац нь улс орны нээлттэй байдлын хэмжээ, түүний эдийн засгийн цар хүрээ, бүтцээс, эдийн засгийн өсөлтийнх нь дотоод, гадаад хүчин зүйлсийн харьцаанаас, бүтцийн урт хугацааны бодлогын зорилгоос хамааран үлэмжхэн ялгаатай байх ёстой нь тодорхой. Янз бүрийн түвшингийн



шалгууруудыг уялдуулан зохицуулах нь зах зээлийн субъектуудын аж ахуйн үйл ажиллагаанд төрийн зүгээс бүдүүлгээр хугалдан оролцох хэрэгтэй гэсэн хэрэг огт биш юм.

Глобалчлагдаж байгаа дэлхий ертөнцөд төрийн эдийн засгийн бодлогын чанарын үүрэг өсөн нэмэгдэж байна. Төр эх орны үйлдвэрлэгч, экспортлогч болон импортлогчдын үйл ажиллагааны таатай нөхцлийг бүрдүүлэхийн тулд энэ бодлогын зорилгыг бизнесийн болон нийт нийгэмтэй хамтран яв цав тодорхой томъёолох ёстой. Ийм практик зөвхөн хөгжингүй орнууд төдийгүй, хөгжиж буй олон оронд өргөн хэрэглэгддэг юм.

Үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь энэ салбарт Монголын гол зорилт болж байна. Байдлыг үндсээр нь өөрчлөхийн тулд оюуны багтаамж ихтэй, ялангуяа эх орны үндэс суурьтай салбаруудад техникийн тэргүүлэх чиглэлүүдийг сонгоход тулгуурласан төрийн зохицуулалтын хэрэгслийг ашиглан бүх элементийг шинэчлэх шаардлагатай.

Дээр дурдсан зүйлсийг үндэслэн дараахи дүгнэлтийг хийж болно. Эдийн засгийн глобалчлалыг гагцхүү дэлхийн аж ахуйн үр ашигийн шалгуурт захирагдсан үйл явц мэтээр хялбарчлан ойлгохоос татгалзах хэрэгтэй. Үнэндээ энэ үйл явцыг зохицуулж, удирдах ажил нь глобал, бүс нутаг, салбар бүс нутгийн болон үндэсний түвшин дэх эрх ашиг, янз бүрийн интеграцийн нэгдэл, олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, олон нийтийн янз бүрийн даралт шахалтын нарийн түвэгтэй мөргөлдөөн, сүлжилтийн дүнд хэрэгжих болно.

### **Интеграци эсвэл харилцан ажиллагаа юу?**

Хэд хэдэн түвшингийн үр ашиг болон тэдгээрийн харилцан нөлөөллийн шалгуурыг харгалзан үзэх шаардлага нь дэлхийн аж ахуй дахь улс орны (үндэсний) эдийн засгийн бүтцийн оролцооны дүр зураг, шинэ шинэ глобал өдөөлтийг хэрхэн тусгаж байгаа байдлыг түвэгтэй болгож байна. Эдгээр тодорхойлолтоор зах хязгаар орнуудыг (хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай) тодорхой таамаглах байдлаар хоёр бүлэгт хувааж болно.

Эхнийхэд нь сул болон дунд зэргийн хөгжлийн түвшинтэй харьцангуй жижиг улсууд хамаарч байгаа бөгөөд тэдгээрээс олонхи нь эдийн засгийн өсөлт, үндэсний аюулгүй байдлыг хангаж, нийгмийн зорилгыг өөрийн үндсэн дээр шийдвэрлэхэд шаардлагатай нөөц, хэрэгтэй салбаруудгүй юм. Ийм улсуудын хувьд гадаад ертөнцтэй өргөн цараатай харилцаа тогтоож, гаднаас өсөлтийн эд материалын болон оюуны түлхэц олж авах нь тогтвортой өсөлтийн замд нийлж,

дэлхийн соёл иргэншлийн зонхилогч урсгалд орох нэн чухал нөхцлийн нэг болж байна. Ийм орнуудын хувьд дэлхийн аж ахуйд холбогдох нь зохистой зам мөн гэж санагддаг.

Энэ бүлгийн орнууд өөрийн эдийн засгийн хувь заяаг нэг орон юм уу бүлэглэл зэрэг ямар нэг томхон бүтэцтэй туйлын нягтаар холбож байгаа юм. Энэ нь жишээлбэл, Төв болон Зүүн Европын орнууд ЕХ-нд нэгдэж, валютын холбоогоор дамжуулан хуучин эзэнт улстай холбогдож, үндэсний эдийн засагтаа гадаад валют хэрэглэх юм уу түүнийг доллартай холбож, бусад зах хязгаарын оронтой эдийн засгийн юм уу гаалийн холбоо юм уу хөгжингүй орнуудыг (НАФТА) оролцуулан холимог холбоо байгуулах явдал юм.

Интеграцичилж байгаа орнуудын үндэсний эдийн засгийн бүтэц нь юуны өмнө (нэлээд хэмжээгээр) гадаад зах зээлийн хэрэгцээ, капитал, болж өгвөл гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаадын технологийг татах боломжоор тодорхойлогдож байна. Зээлдэж авсан технологи орон нутгийн нөхцөл, хэрэгцээнд дасан зохицдог нь зүйн хэрэг бөгөөд гэхдээ гадаад орчин нь дээр нэгэнт тэмдэглэснээр, шаардлагатай салбарууд болон НИОКР-ыг ихээхэн тодорхойлж, ингэхдээ үндэсний эдийн засгийн цогц байдлын харьцангуй их биш хэмжээ нь нийтлэг шинж хэвээр үлддэг.

Тиймээс бусад зах хязгаар болон хөгжингүй бусад оронтой интеграцийн бүлэглэл байгуулах нь үндэсний эдийн засгийн бүтцийн огт байхгүй амин чухал шаардлагатай шижмүүдийг сэлбэх хэрэглүүр, мөн гадаад таагүй нөлөөлөлд тогтвортой байх явдлыг дээшлүүлэх нөхцөл болж байна. Харамсалтай нь, зөвлөлтийн дараахи орнууд (ЕХ болон НАТО-д нэгдэх чиг бодлогыг шийдвэртэй баримталсан Балти орчмын орнуудаас бусад) дэлхийн глобал бүтцүүдэд илүү зөөлөн орох зорилгоор салбар бүс нутгийн болон бүс нутгийн интеграцийн чадавхийг бараг ашиглахгүй байгаа юм.

Энд байгаа эдийн засгийн нэгдлүүд үр ашиггүй юм. Олонхи тохиолдолд ажил хэрэг дүрмийн баримт бичиг, норматив үндэслэл боловсруулах төдийгөөр хязгаарлагдаж, эдгээр нь хамтарсан юм уу үгүйдээ уялдуулан зохицуулсан үйл ажиллагаа болж хэрэгжихгүй нь олонтоо байна. Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд Чөлөөт худалдааны бүс, Гаалийн холбоо байгуулж чадахгүй байна. (Киргиз ДХБ-д элдсэхдээ зөвтгөхийн аргагүй их үүрэг хүлээж, хоёр талын харилцааны олон асуудал шийдвэрлэгдээгүй зэргээс болоод) Зөвлөлтийн дараахи эрэг хавийн орнуудын эдийн засгийн өсөлтийн эрх ашгийн үүднээс Каспийн тэнгисийн нөөцийг ашиглах ажил саатаж байна. Тээврийн зохистой харилцаа бий болгох ажлын ахиц удаан байна.

Зайлшгүй шаардлагатай байгаль, үйлдвэрлэл, санхүүгийн болон оюуны нөөц, түүнчлэн дотоодын хангалттай багтаамж бүхий зах зээлийн ачаар гол нь өөрийн үндсэн дээр хөгжих чадвартай дээр дурдсан томхон орнууд болон улс хоорондын бүтцүүд хоёр дахь бүлэгт хамаарна. Худалдааны хэмжээ, капиталын шилжилт нэмэгдэж байгаа ч, эдгээр орон болон бүс нутгийн нэгдэл гол төлөв дотоод руугаа чиглэсэн, тодорхой хэмжээгээр тусгаарлагдмал хэвээр байгаа юм.

Бидний үзэж байгаагаар, ийм орон болон бүтцүүдийн талаар “дэлхийн аж ахуйд нэгдэх” гэсэн ойлголтыг хэрэглэх нь үндэслэлгүй. “Харилцан ажиллах” юм уу “дасан зохицох” гэсэн нэр томъёо үйл явцын мөн чанарыг илүү нарийн тусган харуулж байна. Дэлхийн аж ахуйд нэгдэх нь интеграцид орж байгаа бүтэц бусдын тоглоомын байгаа дүрмийг хүлээн авч байна гэсэн хэрэг бөгөөд учир нь жин даацын ялгааг харьцуулах аргагүйгээс болоод интеграци нь нийт эдийн засгийн орон зайд тийм их мэдэгдэхүйцээр нөлөөлж чадахгүй юм.

Гол нь өөрийгөө хангах зарчмын үндсэн дээр ажиллаж буй томхон бүтэц эдийн засгийн стратегиа өөрчилж, дэлхийн аж ахуйтай идэвхитэй харилцаанд орж байгаа нь өөр хэрэг юм. Энд илүү нарийн түвэгтэй бүтэц бий болж байна. Шинээр орж байгаа улс орон ч глобал шинжтэй талбайн тоглоомын дүрмийг мөн хүлээн авахад хүрдэг бөгөөд гэхдээ аж ахуйн үйл ажиллагааны гол жин даац нь улс орны дотоодод хэвээр үлдэж байгаа юм. (жишээ нь, АНУ-д ДНБ дэх экспортын хувь хэмжээ 7-8%, Энэтхэгт 9-10%, Хятадад 25% байгаа бөгөөд дэлхийн худалдааны тэргүүлэх орон ЕХ-ны орнуудад энэ харьцаа 20%-ийн эргэн тойронд хэлбэлзэж байгаа юм) Тиймээс шинээр орж буй орон үр ашгийн глобал болон дотоодын шалгуурыг баримжаалж байгаа бөгөөд эдгээр шалгуурыг хослуулахын тулд зохицуулалтын төрийн болон интеграцийн механизмыг ашиглаж байна. Глобал эдийн засгийн үйл явцад ийм орон интеграцийн нэгдэл оролцож байгаа нь дэлхийн нийт аж ахуйд нөлөөлж, энэ аж ахуйг богино хугацааны болон урт хугацааны хэтийн төлвийн аль алин дахь өөрийн байр суурийн өөрчлөлтөөр бас тусгахад хүргэж байна.

Авч үзэж байгаа асуудалтай холбогдон гадаад ертөнцтэй Хятадын эдийн засгийн харилцаа идэвхижиж буй практик хамгийн их сонирхолтой юм. Нэгдүгээрт, энэ үйл явцад 1,5 тэрбум гаруй хүн татагдан орж байна. (Тайвань болон гадаад дахь нутгийн хятадуудтай нягт харилцаатай байгааг харгалзан үзвэл) Хоёрдугаарт, сүүлийн хорин жилийн эдийн засгийн өсөлтийн цар хүрээ, хурдац маш их байгаа нь Хятад улс глобалчлалын өдөөлтөд дасан зохицож байгаа төдийгүй, дэлхийн аж ахуй болон олон улсын эдийн засгийн харилцааны “шинэ архитектурт” улам хүчтэй нөлөөлж байгаа билээ.

Гуравдугаарт, Хятадын эдийн засгийн шинэтгэлийн талынхан градуал байдлаар хандаж, төрийн зохицуулалтын хэрэглүүрийг ашиглахыг илүүтэйд үзэж байгаа юм.

“Хятадын амжилт нь тэнд эхлээд таваарын эдийн засаг бий болгосонтой холбоотой бөгөөд эцсийн бүлэгт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, түүний чанарыг дээшлүүлэх чадвартай үндэсний үйлдвэр нь энэ бодлогын гол институци болж байгаа юм. Эрэлт, үнэ, нийлүүлэлт, үйлдвэр, төр, нийгмийн эрх ашгийг тэнцвэржүүлэх аргыг олсноос хойш удаан хугацааны дараа л Хятадад зах зээлийн аж ахуйн тухай ярьж эхэлж, түүнийг институцчилэх ажлыг яаралгүй хийсэн юм” гэж А.Салицкий бичсэн билээ.<sup>8</sup>

Зарим таамаглалаас үзвэл, 2002-2006 онд БНХАУ-ын гадаад худалдааны өсөлтийн жилийн дундаж хурдац 15%-д хүрч болохоор байна. Хятад, Тайвань ДХБ-ын гишүүн болвол дэлхий нийтийн үйлдвэрлэлийн хэмжээ 2%, экспортын хэмжээ 3%-иар нэмэгдэнэ гэж Вашингтоны Бруклины хүрээлэн дүгнэжээ.

Глобал үйл явцад БНХАУ-ын оролцож буй идэвхитэй оролцоо дэлхийн үйлдвэрлэл болон олон улсын худалдаанд нөлөөлж байгаа нь өөрийгөө хангах зарчимд үндэслэсэн Хятадын аж ахуйн асар их цараатай, өвөрмөц тогтолцоо дэлхийн аж ахуйд нэгдэж байна гэхээсээ, глобалчлалын өдөөлтөд дасан зохицох зорилгоор уг аж ахуйтай харилцан ажиллаж байна хэмээн нотлох боломжийг олгож байгаа юм.

Онолын үүднээс “интеграци” гэсэн нэр томъёо орчин үеийн дэлхийн олон туйлт байдлын тухай хятадын төсөөлөлтэй зохицохгүй байна. Харин “дасан зохицох” болон “харилцан ажиллах” гэсэн нэр томъёо нь гадаад ертөнцтэй тус орны тогтоосон эдийн засгийн харилцааны шинж чанарт илүү тодорхой нийцэж байна. Атлантын эвслийн байдлаар тайлбарлаж буй глобалчлал түгээмэл шинжтэй гэдгийг няцаасан үзэл бодол Хятадад давамгайлж байгаа юм. Ингэхдээ хүн төрөлхтөний эдийн засгийн болон бусад зарим үйл явцын глобал шинжийг огт үгүйсгэхгүй байгаа билээ.

Глобалчлалын тухай хятадын үзэл баримтлалын мөн чанар нь үйлдвэр, дэд салбар, салбар г.м. юм уу нэгдмэл нэг зүйл болох тус орны аж ахуйн тогтолцоо зэрэг энэ үйл явцын субъектуудыг тодорхойлоход оршиж байна. Энэ үүднээс авч үзвэл, дэлхийн аж ахуйд нэгдэх биш, харин түүнтэй харилцан ажиллах зорилго гэж ойлгох хэрэгтэй нь тодорхой юм. Хятад улс гадаад ертөнцөд дасан зохицох чиг бодлогыг мөрдлөг болгохдоо олон зах хязгаар орны хувьд онцлог болсон дотоодын зах зээлийг хохироон, гадаад зах зээлд хэтэрхий холбогдох явдлаас зайлсхийж чадсан юм.

Шаардлагатай нөхцөл бүрдэх хүртэл дэлхийн аж ахуйд нэгдэн оролгүйгээр гадаад ертөнцтэй харилцан ажиллах стратеги, бодлого үр нөлөөтэйг XX зууны сүүлийн хорин таван жил болон энэ зууны эхний жилүүдийн БНХАУ-ын хөгжлийн дүн нотолж байна. Үндэсний аж ахуйн тогтолцоо нь олон улсын хөдөлмөрийн хуваарьт нэгэнт татагдан орсон байдлын онцлогийг харгалзан, Бразил, Энэтхэг, Пакистан, Индонез (хямралыг гэтлэн давсаны дараа), Орос зэрэг томхон орнууд дэлхийн аж ахуйд оролцох ийм стратеги, бодлогыг ямар нэг хэмжээгээр хэрэглэж болох нь тодорхой юм.

Улс орны хөгжилд гадаад хүчин зүйлийн гүйцэтгэж буй үүрэгт Хятадын шинэтгэлийн талынхны өгсөн дүгнэлт, Азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудын экспортыг хэт баримжаалсан байдал, гадаадын технологи, хөрөнгө оруулалтаас хараат байгаа явдал бүхий эдгээр орны практикийг заавал давталгүйгээр аж үйлдвэржилтийн дараахи түвшинд аж ахуйн зарим хэсгийг гаргах боломж нь Оросын шинжээчид болон эдийн засагчдад практикийн хувьд их сонирхолтой юм. Аж үйлдвэрийн хэд хэдэн дээд давхаргыг нурааж, технологийн хоцрогдолд орж, улс орон тарж бутарсаны дараа ажиллах хүчний мэргэшил, оюуны чадавхи буурч, шинэтгэлийг бодлогогүйгээр, яаруу сандруу хийснээс болоод бий болсон нөөцийн салбарууд болон тэдгээрийн экспортыг өрөөсгөлөөр баримжаалсан хэмжээ зөвтгөх аргагүй их болсон бүтцийн тэр байдлыг даван туулах зорилт Оросын эдийн засгийн өмнө тулгарч байна.

Тогтолцоог бүрдүүлэгч хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг төр тодорхойлохгүйгээр, аж ахуйн ерөнхий өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор салбаруудын хооронд орлогыг дахин хуваарилж, бүтцийг нь аажмаар өөрчлөхөд чиглэсэн экспортыг төрийн хөндлөнгийн оролцоогүйгээр цаашид өргөжүүлэх нь Оросын эдийн засгийг гадаад худалдааны занганд орж, дэлхийн аж ахуйн түүхий эдийн нэг бүс нутаг гэсэн түүний одоогийн статусыг бататгахад улам бүр ойртуулна.

Тус бүрдээ ойрын хүрээллийнхээ хувьд эдийн засгийн талаар татах төв болж буй нөхцөлд дэлхийн аж ахуйн өөрчлөлтөд төвийн болон зах хязгаарын зарим томхон орон дасан зохицож байгаа нь одоо салбар бүс нутгийн болон бүс нутгийн эдийн засгийн нэгдлүүд (ЕХ дорно зүг тэлж, АСЕАН, Евроазийн эдийн засгийн холбоонд оролцогчдын тоо нэмэгдэж байгаа) өргөжин тэлэхийн зэрэгцээгээр, түүнчлэн жишээ нь зөвлөлтийн дараахи дөрвөн орны (Орос, Украин, Казахстан, Беларусь) ерөнхийлөгч нар эдийн засгийн нэгдмэл орон зай байгуулах бодолтой байгаа тухайгаа мэдэгдэж, шинэ шинэ нэгдэл байгуулахыг эрмэлзэж байгаагийн зэрэгцээгээр эдийн засгийн

глобалчлал улам өргөжин, гүнзгийрэх харилцан уялдаатай, гэхдээ зөрчилтэй хоёр хандлагыг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагааны хүрээ нь түгээмэл шинжтэй глобал үйл явц, томхон улсууд болон тэдгээрийн эдийн засгийн бүлэглэлүүдийн хүрээнд өрнөж буй салангид үйл явцын аль аль нь юм. Ойрын ирээдүйд энэ хоёр үйл явц нь глобал эдийн засаг тийш урагшлах болон түүний зарим элемент (бүс нутгийн болон салбар бүс нутгийн бүлгүүд) харьцангуй тусгаарлагдмал байдалтай болоход түлхэц үзүүлж, улмаар зонхилох болно гэсэн сэтгэгдэл төрж байна.

Глобалчлалын шинж чанар, үр дагаварын тухай хурц маргаан шүүмжлэлд нийгмийн эдийн засгийн амьдрал дахь төрийн үүрэг гол байр суурьтай нь эргэлзээгүй юм. Глобалчлалын өмнөх үеийн “зах зээлийнхэн” болон “төрийнхний” байнга хийж буй маргаан, дурдаж байгаа баримт шалтаглал дээр улс орны гадна үүсч, олонхи тохиолдолд үндэсний зохицуулагч механизмын хяналтын гадна үлдэж байгаа глобалчлалын өдий төдий өдөөлтөд төрийн өгөх хариултыг тодорхойлж, онолын хувьд үндэслэх шаардлага нэмэгдсэнд асуудлын хурц бөгөөд нарийн түвэгтэй байдал оршиж байна.

Энэ асуудал судалгааны хүрээнээс хальж байгаа ч, глобалшиж буй дэлхийн аж ахуйд эдийн засгийн даатгалын бүтцийг интеграцчлах үйл явц дахь төрийн үүргийг товчхон ч гэсэн тогтоож ярих нь зүйтэй болов уу. Глобал үйл явц маш их хурдтай байгаа учир дунд зэргийн болон буурай хөгжилтэй орнуудын уламжлалт тогтолцооны зах зээлийн нэг хэсэг зохицуулагч л салбар болон өөр хоорондоо холбоотой бүлэг салбар, бүс нутаг болон нийт үндэсний эдийн засгийн түвшинд тус тусдаа оролцогчдын хүрээний гадна зохистой үр дүнд хүрэх явдлыг хангаж чадахгүй юм. Аж ахуйн субъектууд гарч буй өөрчлөлтөд тэр бүр байнга дасан зохицож, эдгээр өөрчлөлтийг зөвөөр тусгаж амждаггүй. Үүнтэй холбогдон үндэсний эдийн засгийн байр сууринаас зохистой үр дүнд хүрэх зорилгоор үйл явцад янз бүрийн түвшинд оролцогчдын эрх ашгийг зөвшин тохирох механизм зайлшгүй шаардлагатай болж ирж байна.

Глобалчлалын нөлөөгөөр төр зарим уламжлалт үүргээс, юуны өмнө компани, үйлдвэрүүдийн аж ахуйн үйл ажиллагаанд шууд хутгалдан оролцохоос үнэхээр татгалзах хэрэгтэй юм. Гэвч глобал үйл явц нь түүний өмнө олон шинэ шинэ зорилтыг шийдвэрлэх шаардлагыг дэвшүүлэн тавьж байна. (олон улсын олон талын гэрээ, хэлэлцээрт оролцох, эдийн засгийн бодлогыг уялдуулан зохицуулах, интеграцийн нэгдлийн хүрээнд хамтарсан үйл ажиллагаа явуулах, хүрээлэн байгаа орчныг хамгаалах асуудал, тогтвортой хөгжил, ядууралтай тэмцэж, эх орны бизнесийг дэмжих асуудлаархи дээд хэмжээний уулзалтуудаас

хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор олон улсын эдийн засгийн байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоон, хамтран ажиллах, өрсөлдөөн хурцдаж буй нөхцөлд нийгмийн хангамж, гаднын цохилтыг эсэргүүцэх шаардлагыг хангах г.м.)

Тиймээс санал шүүмжлэлийн төв нь эдийн засаг дахь төрийн үүргийг няцаах юм уу “ингэж няцаах нь их юм уу бага болсоныг” тодруулахаас төрийн удирдлагын үр ашгийг дээшлүүлэх аргыг эрж хайх явдал, глобал өдөөлтийн хариуд түүний чанарын шинэ үүрэг рүү шилжиж байна. Төр эрх мэдлийг монопольчлох явдлаа алдсан нь түүний үүргийг бууруулж байгаа хэрэг биш юм. Үндэсний төр тэр ч байтугай глобалчлалыг харгалзахдаа, өөрийн гол гол байр суурийг хэвээр хадгалж байгаа бөгөөд гэхдээ төр эдгээр байр сууриа олон талаар шинээр бүрдүүлэх ёстой.

Глобалчлалын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд зах зээлийг чөлөөлөх гэж яарах биш, харин төрийн ухаалаг оролцоог хүчтэй болгох хэрэгтэй гэж Ж.Стиглиц үзэж байна.<sup>9</sup> Өрнүүлж буй санал шүүмжлэл глобалчлалын үзэл баримтлалд түлхэц болж, “бизнес-төр-эдийн засгийн глобал үйл явцын үндэснээс дээгүүрх болон олон улсын зохицуулагчид” гэсэн гурвалжинд үр нөлөөтэй харилцан ажиллахад туслана хэмээн найдаж болно. Ойрын ирээдүйд энэ гурвалын харилцан ажиллагааны шинж чанар дэлхийн аж ахуйн байгуулал болон эдийн засгийн глобал үйл явцын хөгжлийг шийдвэрлэх хэмжээгээр тодорхойлно хэмээн санагдаж байна.

Дээр дурьдсан бүхнийг дүгнэж хэлэхэд, социализм бол маш өндөр өртөгөөр бүтдэг. Гэвч социализм түүх болон хоцорсон тул одоо бидний өмнө яаж эдийн засгаа түргэн сэргээх, өсөлтөө нэмэгдүүлж, бусдыгаа гүйцэх вэ гэсэн асуудал тулгарсан байна. Урт хугацааны туршид эдийн засгийн өндөр өсөлттэй байх боломж бий. Үүний тулд өсөх нөхцлийг бүрдүүлэх буюу сайн тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай. Энэхүү тогтолцоо нь байгуулахад улс төрийн хувьд бэрхшээлтэй тулгардаг боловч үнэндээ маш энгийн зүйл юм. Үүнд татвар бага, нийгмийн халамжийн зардал бага, хувийн өмчид тулгуурласан систем орно. Энэ систем нь биеэ даасан төв банктай учир инфляци бага түвшинд байна. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, хүнд суртал, авилгалыг бага байлгах үүднээс төрийн оролцоо хязгаарлагдмал, зохицуулалт багатай чөлөөт зах зээлийг бүрдүүлсэн бөгөөд хууль ёс хэрэгжих эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, шүүх засаглалыг сайн хөгжүүлсэн байна.

## ДУГНЭЛТ

Янз бүрийн төрөл, түвшингийн субъект болох тусдаа пүүс, улс орон, бүс нутгийн орнуудын нэгдэл, олон улсын байгууллагууд эрх тэгш нөхцлийн үндсэн дээр хамтран ажиллаж, өрсөлдөж байгаа олон туйлт, нэгдмэл ертөнцийн орчин үеийн загварууд нь үндэсний тусдаа, туйлын нийгэмчлэгдсэн эдийн засаг ажиллах боломжгүйг практикт нотолсон зүйлийг байнга илрүүлж байна. Харилцан ажиллах шаардлагыг хүний нийгэм оршин тогтносон бүр эхний шатуудад ойлгосон бөгөөд харин энэ харилцан ажиллагааг хангаж буй дэлхийн аж ахуйн харилцааны систем нь олон улсын худалдааны харилцаанаас олон улсын капиталын шилжилт тийш, олон улсын солилцооноос олон улсын үйлдвэрлэл тийш хөгжсөн юм. Орчин үеийн шатанд ч олон улсын эдийн засгийн харилцааны хөгжлийг дууссан гэж үзэж болохгүй. Түүгээр ч барахгүй, бүх эдийн засагч олон улсын эдийн засгийн харилцааг дэлхийн эдийн засгийн хамгийн эрчимтэй хөгжиж буй салбарын нэг гэж үзэн, нэгдмэл үзэл бодол баримталж байгаа юм.

Тодорхой илэрч байгаа зөрчил ч дэлхийн аж ахуйн харилцааны цаашдын хөгжилд түлхэц үзүүлж болох бөгөөд тодруулбал нэг талаас, дэлхийн эдийн засаг, олон улсын эдийн засгийн харилцаанд болж буй үйл явцыг глобалчлагдаж, нөгөө талаас, үндэсний зах зээлээ гадаадын өрсөлдөөнөөс хаацайлахыг зарим улс эрмэлзэж буйд орших үндэсний үзэл нь глобалчлалын эсрэг тавигдсаныг бид ажиглаж байна. Дэлхийн аж ахуйн бүх субъект нь өөрийгөө хангах нөхцөлд эдийн засгийн дэвшилд хүрэх боломжгүйг ойлгон, глобалчлалын үйл явцад орохоос аргагүйд хүрсэн юм. Харин бүрэн глобалчлал нь дэлхийн эдийн засгийн субъектуудын хэтэрхий ялгавартай байдлыг өдөөж байна. Туйлширсан үндэсний үзлээс орчин үеийн шатны глобалчлал тийш урагшлах үйл явц Монголд ч хамаатай юм.

Монгол Улс дэлхийн аж ахуйд интеграцчлах нь тус орны эдийн засаг, улс төр, нийгмийн хөгжлийн тэргүүлэх зорилтын нэг байх ёстой. Дэлхийн эдийн засаг, олон улсын эдийн засгийн харилцаанд болж буй үйл явцыг судлах нь манай орон бүр одоо бусад орон, бүс нутагтай гадаад эдийн засгийн харилцаагаа үр нөлөөтэй төвхнүүлэх боломжтой тэр чиглэлүүд, түүнчлэн ирээдүйд тус улсын баримжаалах ёстой тэр чиглэлүүдийг тодорхойлох боломж олгож байна.



## ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Globalization versus Mondialization: Private Gain, Public Good and Common Understanding, <http://one-world6.org/ecdpm/pubs/indra.htm>

2. “Практика глобализации: игры и правила новой эпохи. М., 2000, Ч. 1. Гл. 2.

3. Независимая газета. 2002.06.20

4. Иноземцев.В.Л. Социально-экономические проблемы XX века: попытка нетрадиционной оценки. М., 1999. 43-52

5. А.Дагаев. Новые модели экономического роста с эндогенным технологическим прогрессом //МЭ и МО. 2001. №6).

6. World Economic Outlook. Wash., 2000. Transition Newsletter. October, November, December 2001. V.12. №4.

7. Finance and Development. IMF. Wash., September 2001.V.39. №3.P.14

8. Салицкий А.И. Взаимодействие КНР с мировым хозяйством. Московский Научный общественный фонд. Научные доклады. 2001. №127. С. 17.

9. “Мировые дискуссии. 14.06.2002; Financial Times. 09.07.2002; Меньшиков С. Народ платит цену глобализации // Слово. 12.07.2002